



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/50

Хажуу шинэ-Ус

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/439 дүгээр захирамжаар “Угийн бичгийг хөтлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай”, мөн өдрийн А/440 дугаар захирамжаар “Угийн бичигтэн удамынханыг шалгаруулах болзол батлах тухай”, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 08/667 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Угийн бичгийг хөтлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Энхтуяа	(Төв номын санч)
Нарийн бичиг	Н.Болор-Эрдэнэ	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
Гишүүд	Э.Золжаргал	(Сургуулийн нийгмийн ажилтан)
	П.Отгонжаргал	(Цэцэрлэгийн арга зүйч)
	Г.Болор-Эрдэнэ	(Эрүүл мэндийн төвийн дүн бүртгэгч)
	Р.Эрдэнэбулган	(Соёлын төвийн өвийн ажилтан)
	Б.Гүнсэнтүг	(1 дүгээр багийн Засаг дарга)
	Г.Батчулуун	(2 дугаар багийн Засаг дарга)
	Л.Батбаатар	(4 дүгээр багийн Засаг дарга)

2. Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын дагуу мэдээлэл сурталчилгааг сайтар хийж, өрх бүрээр угийн бичиг хөтлүүлэх, үлгэр жишээ хөтөлж буй айл, өрхийг нийтийг хамарсан хурал, цуглаан зөвлөгөөний үеэр сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Угийн бичиг хөтөлж буй айл, өрхийн нарийвчилсан судалгааг гаргаж, цахим мэдээллийн сангийн өөрчлөлт, баяжилтийг тухай бүрт нь хийж хэвшүүлэх ажлыг Соёлын төвийн соёлын өвийн ажилтан (Р.Эрдэнэбулган)-д үүрэг болгосугай.

4. Зохион байгуулсан ажлын болон угийн бичиг хөтөлсөн айл, өрхийн мэдээллийг улирал бүрийн сүүлийн 20-ны дотор Нийгмийн бодлогын хэлтэс, Соёл, урлагийн газарт хүргүүлж байхыг Ажлын хэсгийн ахлагч (Х.Энхтуяа)-д даалгасугай.

ДАРГА  Т.АРИУНАА

